

АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГЫГ БЭЛТГЭХ ЗААВАР

Нэгдүгээр бүлэг: НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Аж ахуйн нэгж нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө.
2. Даатгал, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллага, банк болон түүнтэй адилтгах санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх зааврыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын шаардлагууд ба энэ заавартай нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тусгайлан баталж мөрдүүлнэ.
3. Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайланг улирал бүр батлагдсан маягтаар гаргана.
4. Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.
5. Санхүүгийн тайлан, тодруулга дахь үзүүлэлтийг хорогдуулж буй дүнг хасах тэмдэгтэйгээр илэрхийлнэ.
6. Санхүүгийн тайлангийн тодруулгад мэдээллийг заавал тодруулна.

Санхүүгийн тайлангийн зорилт

1. Санхүүгийн тайлан нь гадны болон дотоодын хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардагдах тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, эздийн өмч, өр төлбөр), санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний) – ийн талаарх мэдээллээр хангана.
2. Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэх зарчим

Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

1. Санхүүгийн тайланг энэ заавар болон СТОУС¹ – ын бүх шаардлагад нийцүүлэн гаргахын тулд аж ахуйн нэгжийн удирдлага нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулан мөрдөх;
2. Аж ахуйн нэгжийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар гаргах;
3. Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар² бэлтгэх;
4. Санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгалах;
5. Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байх;

¹Энэ зааварт Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж дурьдсаныг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУС – ын Зөвлөл) – өөс баталсан стандарт болон тайлбарыг хамаатуулж ойлгоно.

²Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

6. Санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанар буюу үүргийнх нь дагуу ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулах;
7. Энэ заавар болон Санхүүгийн тайлагналын олон улсын холбогдох стандартаар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн нэгж хөрөнгө, өр төлбөр эсвэл орлого, зардлыг цэвэр дүнгээр гаргахгүй байх.

Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд

Иж бүрэн санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан;
2. Орлогын дэлгэрэнгүй тайлан;
3. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
4. Мөнгөн гүйлгээний тайлан;
5. Санхүүгийн тайлангийн тодруулга орно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Аж ахуйн нэгж нь дараах мэдээллийг толилуулна. Үүнд:

1. Тайлагнагч аж ахуйн нэгжийн нэр, өмнөх тайлант үеийн эцсийн мэдээлэл дэх аливаа өөрчлөлт;
2. Санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан³ болох тухай;
3. Тайлант үеийн эцсийн өдөр, санхүүгийн тайлан эсхүл тодруулгын хамрах хугацаа;
4. Толилуулгын валют⁴;
5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлсэн тухай мэдээлэл хамаарна.

Хоёрдугаар бүлэг: САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч гэж ангилна. Аж ахуйн нэгж бүр өөрийн үндсэн үйл ажиллагааны шинж чанарт үндэслэн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд ангилан, тодорхой нэг хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон толилуулна.

Хөрөнгө

Хөрөнгийг⁵ эргэлтийн, эргэлтийн бус гэж ангилна.

Эргэлтийн хөрөнгө

Дараах хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд хамруулан ойлгоно. Үүнд:

- (а) Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд ашиглахаар хүлээгдэж байгаа, эсхүл худалдан борлуулахаар эзэмшиж байгаа;
- (б) Нэн түрүүнд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа;
- (в) Тайлант өдрөөс хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа;

³Тусдаа санхүүгийн тайлан гэж охин компанийн хөрөнгө оруулагч болох *толгой компанийн*, хамтарсан хяналттай аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалттай буюу мэдэгдэхүйц нөлөөтэй, хөрөнгө оруулалтаа өртгийн аргаар аль эсхүл СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр – ийн дагуу бүртгэдэг хөрөнгө оруулагчийн толилуулж буй санхүүгийн тайланг хэлнэ.

⁴Толилуулгын валют гэж санхүүгийн тайланг толилуулахад ашиглаж буй валютыг хэлнэ.

⁵Хөрөнгө гэж аж ахуйн нэгжийн өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж буй нөөцийг хэлнэ.

- (г) Хөрөнгийн солилцоог хязгаарласнаас бусад тохиолдолд, тайлант өдрөөс хойш 12 сарын дотор өр төлбөрийг барагдуулахад ашиглах мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө.

Эргэлтийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс дахь мөнгө, банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөр чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

2. Дансны авлага

Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

4. Бусад авлага

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн авлага болон бусад авлага хамаарна.

5. Бусад санхүүгийн хөрөнгө

Үүнд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хамаарна. Санхүүгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахад *СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*, *СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр*, *НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга* – ийг дагаж мөрдөнө.

6. Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

НББОУС 2 *Бараа материал* – д заасны дагуу бараа материалыг өртөг⁶ болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрийн эцэст тооцно.

Санхүүгийн байдлын тайланд бараа материалыг дансны цэвэр дүнгээр нь толилуулж, санхүүгийн тайлангийн тодруулгад дараах байдлаар ангилан харуулна. Үүнд:

- (а) Түүхий эд материал: үндсэн түүхий эд, туслах материал;

⁶ Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбоотой гарсан зардлууд орно. Үйлчилгээний байгууллагын хувьд бараа материалын өртгийг үйлдвэрлэлийн өртгөөр хэмжих бөгөөд өртөгт нь үйлчилгээ үзүүлэхэд шууд оролцож буй ажилчдын хөдөлмөрийн болон бусад нэмэлт зардлуудыг хамруулна.

- (б) Дуусаагүй үйлдвэрлэл: үйлдвэрлэж дуусаагүй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг;
- (в) Бараа, бэлэн бүтээгдэхүүн: борлуулах зориулалттай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулах зорилгоор бусдаас худалдан авсан бараа;
- (г) Хангамжийн материал: аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагдах, цаашдаа зардал болгох хангамжийн материал, шууд зарцуулагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, бусад хангамжийн шинжтэй зүйлс хамаарна.

7. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

8. Бусад эргэлтийн хөрөнгө

Дээр дурьдаагүй эргэлтийн хөрөнгө (тухайлбал, эргэлтийн биологийн хөрөнгө) хамаарна.

9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)

Эргэлтийн бус хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөн олж авах бол уг хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийг “Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө” гэж ангилна. Энэхүү хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийг *СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* – д заасны дагуу бүртгэнэ.

Эргэлтийн бус хөрөнгө

Санхүүгийн байдлын тайланд эргэлтийн бус хөрөнгийг дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө

Нэгээс дээш тайлангийн хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна.

Үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь харуулна.

Үндсэн хөрөнгийн ангилал

Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна. Үүнд:

- (а) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;
- (б) Барилга байгууламж: Бүх төрлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, янз бүрийн талбай зэрэг дэд бүтцийн шинжтэй зүйлс;

- (в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;
- (г) Тээврийн хэрэгсэл : Бүх төрлийн тээврийн хэрэгслүүд;
- (д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд;
- (е) Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд;
- (ж) Бусад үндсэн хөрөнгө: Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна.

НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* – д заасны дагуу үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ.

Өртгийн загварын дагуу үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь бүртгэнэ.

НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* - д заасны дагуу үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед тухайн хөрөнгийн харьяалагдаж байгаа үндсэн хөрөнгийн ангийг бүхэлд нь дахин үнэлнэ. Хөрөнгийн дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна.

Дахин үнэлгээний үр дүнд үндсэн хөрөнгийн дансны үнэ нэмэгдэх, буурах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү (бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дүн) - г орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт, дахин үнэлгээний олз, гарз (ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн) - ыг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад ашиг (алдагдал) - ийн хэсэгт тус тус харуулна.

Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн *дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүүг* эздийн өмчийн хэсэгт “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлуулан бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг данснаас хасах үед “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлагдсан тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу түүнийг захиргааны зорилгоор ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдэл тооцно. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжид үндэслэн сонгоно; сонгосон аргыг тайлант үе бүрт тогтвортой мөрдөнө.

Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг (түүнийг бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд) ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг санхүүгийн тайланд тодруулна.

2. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Биет бус хөрөнгийн ангилал

Биет бус хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- (а) Зохиогчийн эрх;
- (б) Компьютерийн програм хангамж: Програм хангамж, мэдээллийн сан;
- (в) Патент;
- (г) Барааны тэмдэг;
- (д) Тусгай зөвшөөрөл: Тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;
- (е) Газар эзэмших эрх;
- (ж) Бусад биет бус хөрөнгө: Барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардал, хөгжүүлэлтийн зардал⁷.

Биет бус хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг нь ашиглан бүртгэнэ.

НББОУС 38 *Биет бус хөрөнгө* – д заасны дагуу биет бус хөрөнгийн дахин үнэлсэн дүн нь дараагийн тайлант үеийн хуримтлагдсан хорогдол ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна.

Дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ нэмэгдэх, буурах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү (бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дүн) - г орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт, дахин үнэлгээний олз, гарз (ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн) - ыг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад ашиг (алдагдал) - ын хэсэгт тус тус харуулна.

Биет бус хөрөнгийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн *дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүүг* эздийн өмчийн хэсэгт “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлуулан бүртгэнэ. Биет бус хөрөнгийг данснаас хасах үед “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлагдсан тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

Биет бус хөрөнгийн хорогдол

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжид үндэслэн шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга эсхүл бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргуудаас аль нэгийг нь сонгон хэрэглэнэ. Сонгосон хорогдуулалтын арга нь аж ахуйн нэгжийн хөрөнгөөс хүртэх эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлж чадахгүй байвал аж ахуйн нэгж нь шулуун шугамын аргыг хэрэглэнэ. Тодорхой ашиглалтын хугацаагүй биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдлын дүнг санхүүгийн тайланд тодруулна.

3. Биологийн хөрөнгө

Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгөнд хамаарах амьд амьтан, ургамал зэргийг эргэлтийн бус биологийн хөрөнгөөр бүртгэнэ. Биологийн хөрөнгийг НББОУС 41 *Хөдөө Аж ахуй* – йн дагуу үнэлж бүртгэнэ.

4. Урт хугацаат хөрөнгө оруулалт

⁷ НББОУС 38 *Биет бус хөрөнгө* –д заасны дагуу биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөх хөгжүүлэлтийн зардал хамаарна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг НББОУС 28 *Хараат компани дахь хөрөнгө оруулалт*, НББОУС 31 *Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо*, НББОУС 32 *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга*, СТОУС 7 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*, СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр* – ийн дагуу бүртгэж, тусдаа санхүүгийн тайланд НББОУС 27 *Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан* – ийн дагуу толилуулна.⁸

5. Хайгуул ба үнэлгээний хөрөнгө

СТОУС 6 *Ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээ* – д заасны дагуу аж ахуйн нэгж ямар зардлуудыг хайгуул ба үнэлгээний хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхойлж, уг бодлогоо тууштай мөрдөнө. Тухайлбал, хайгуулын бэлтгэл ажил, газар зүйн байршил, геологи, геохими болон геофизикийн судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг хийх, малталт хийх, дээж авах болон хайгуулын явцад техник эдийн засгийн үндэслэл ба арилжааны үр ашгийн боломжийг үнэлэхтэй холбоотой гарах зардлууд орно.

Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг Сангийн сайдын 2011 оны 12 тоот тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журам” болон СТОУС 6 *Ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээ* – ийн дагуу бүртгэнэ.

6. Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгөнд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна. Хойшлогдсон татварын хөрөнгийг НББОУС 12 *Орлогын албан татвар* – ын дагуу тооцож бүртгэлд тусгана. Хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглагдаагүй татварын алдагдлыг ашиглаж болохуйц татвар ногдуулах орлого олох магадлалтай тэр хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэс бүрт хянаж үзнэ. Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна. Энэхүү бууралтыг хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалтай болсон үед буцаана.

7. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох эсхүл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг хамруулна.

НББОУС 40 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* – д заасны дагуу уг хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед бодит үнэ цэнэ эсхүл өртгөөр нь бүртгэнэ. Сонгосон загвараа хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгө (үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөс бусад) - нд хэрэглэнэ.

Бодит үнэ цэнийн загварын дагуу хөрөнгийг анхны хэмжилтээс хойш бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Өртгийн загварын дагуу хөрөнгийг анхны хэмжилтийн дараа элэгдүүлсэн өртөг (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн)-өөр бүртгэнэ. Санхүүгийн байдлын тайланд уг хөрөнгийг дансны цэвэр дүнгээр нь харуулна.

⁸ НББОУС 27 *Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан* – д зааснаар аж ахуйн нэгж тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхдээ охин компани, хамтарсан хяналттай аж ахуйн нэгж болон хараат компани дахь хөрөнгө оруулалтыг өртгөөр нь эсхүл СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр* -ийн дагуу бүртгэнэ.

8. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Энэ хэсэгт дээр дурьдаагүй эргэлтийн бус хөрөнгийг хамруулна. Тухайлбал, аж ахуйн нэгжийн урт хугацаат зээлийн авлага болон бусад нэг жилээс дээш хугацаанд цуглуулах урт хугацаат авлагыг энэ хэсэгт толилуулна.

Өр төлбөр

Өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

Богино хугацаат өр төлбөр

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр гэнэ. Богино хугацаат өр төлбөрийг төлөгдөх дүнгээр нь бүртгэж санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан харуулна. Үүнд:

1. Дансны өглөг

Үүнд бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

2. Цалингийн өглөг

Ажилчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өр төлбөрийн дүн хамаарна.

3. Татварын өр

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна.

4. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг

Цалингаас суутгасан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдлийг тооцон энэ хэсэгт тусгана.

5. Банкны богино хугацаат зээл

Энд нэг жил хүртэлх хугацаатай банкнаас авсан зээлийг тусгана.

6. Хүүний өглөг

Богино болон урт хугацаат зээл, өрийн үнэт цаастай холбоотой үүссэн, төлөгдөөгүй байгаа хүүний төлбөрийн дүнг энд тусгана.

7. Ногдол ашгийн өглөг

Тухайн аж ахуйн нэгжийн удирдах эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-д төлөхөөр зарласан ногдол ашгийг энэ дансанд бүртгэнэ. Зөвхөн мөнгөн хэлбэрийн ногдол ашгийн тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг богино хугацаат өр гэж үзнэ.

8. Урьдчилж орсон орлого

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж “Урьдчилж орсон орлого” дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед дебитлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэнэ.

9. Нөөц (өр төлбөр)

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн үүрэг хариуцлагыг төлөх магадлалтай, төлбөрийн дүнг тооцоолох боломжтой болсон үед нь нөөц гэж хүлээн зөвшөөрнө.

Нөөцийн бүртгэлд НББОУС 37 *Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө* – г мөрдөнө.

Баталгаат засварын өр, нөхөн сэргээлт⁹ болон бусад өр төлбөртэй холбоотойгоор байгуулсан нөөцийн дүнг тодруулна. Нөөц (өр төлбөр)-ийн тайлант хугацаанд хамаарах хэсгийг богино хугацаат өр төлбөрийн хэсэгт толилуулна.

10. Бусад богино хугацаат өр төлбөр

Бизнесийн үндсэн үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үүссэн өр, бизнесийн үйл ажиллагааны явцад үүссэн төрөл бүрийн суутгалууд, зардалд шингээж тооцсон төлөгдөөгүй өр, урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, худалдан авагчид болон ажиллагчдаас авсан буцаан төлөх мөнгөн барьцаа, холбоотой талаас авсан богино хугацаат зээл болон бусад дээр дурьдаагүй богино хугацаат өрийг энэ хэсэгт хамруулна.

11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр

СТОУС 5 *Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* – д заасны борлуулах зорилгоор эзэмшиж бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөрийн дүнг толилуулна.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Урт хугацаат зээл

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

2. Нөөц (өр төлбөр)

Аж ахуйн нэгжийн баталгаат засварын өр, нөхөн сэргээлт болон бусад өр төлбөртэй холбоотойгоор байгуулсан нөөцийн урт хугацааны дүн хамаарна.

3. Хойшлогдсон татварын өр

Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ. Хойшлогдсон татварын өрийг НББОУС 12 *Орлогын албан татвар* – ын дагуу тооцож бүртгэлд тусгана.

4. Бусад урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат бонд, өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүнг энэ хэсэгт толилуулна.

⁹ Газрын тосны хөрөнгө, уул уурхайн тоног төхөөрөмжүүдийг хаах болон хог хаягдлыг цэвэрлэх зардлууд үүнд хамаарна.

Эздийн өмч

Аж ахуйн нэгжийн өр төлбөрөө төлсний дараагаар үлдэх цэвэр хөрөнгийн хэмжээг эздийн өмч гэж үзнэ. Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Өмч

Аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч *өмчийг* хувьцаат капитал, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хоршоологчдын хувь нийлүүлсэн хөрөнгө гэж нэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд өмчийг төрийн болон хувийн өмч гэж ангилж толилуулна.

2. Халаасны хувьцаа

Компаниуд гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан халаасны хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна. Халаасны хувьцаа нь гаргасан хувьцааны тоонд орж тооцогдох боловч эргэлтэнд байгаа хувьцааны тоонд орохгүй. Аж ахуйн нэгж нь гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах, борлуулах, гаргах, хүчингүй болгох үед үүссэн олз (гарз)-ыг ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд халаасны хувьцааны нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэнэ. Хэрэв халаасны хувьцаатай холбоотой дээрх гүйлгээнээс гарз үүссэн бөгөөд халаасны хувьцааны нэмж төлөгдсөн капитал данс дебит үлдэгдэлгүй бол алдагдлын хэмжээгээр хуримтлагдсан ашиг дансыг бууруулна.

3. Нэмж төлөгдсөн капитал

Компанийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс нь илүү байвал зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд хуримтлуулан бүртгэнэ. Санхүүгийн тайлангийн тодруулгад нэмж төлөгдсөн капиталыг энгийн хувьцааны, давуу эрхтэй хувьцааны, халаасны хувьцааны гэж тус тусад нь тодруулна.

Хувьцааны нэрлэсэн үнэ зах зээлийн үнээс өндөр байгаа үед нэмж төлөгдсөн капитал данс нь сөрөг тохируулах данс болно.

4. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд хуримтлуулан бүртгэнэ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - өсөлт, үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүнгээр нэмэгдүүлнэ.¹⁰ Харин бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - бууралт, үнэ цэнийн бууралтын гарз, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр энэ дансыг бууруулна.

5. Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг хөрвүүлснээс болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн валют толилуулгын валютаас ялгаатай байх үед санхүүгийн тайланг толилуулгын валют руу хөрвүүлснээс¹¹ үүссэн ханшийн зөрүүний хуримтлагдсан дүнг “гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц” гэж эздийн өмчийн хэсэгт

¹⁰ НББОУС 16 *Үндсэн хөрөнгө*, НББОУС 36 *Хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, НББОУС 38 *Биет бус хөрөнгө* – д заасны дагуу бүртгэнэ.

¹¹ Хэрэв аж ахуйн нэгжийн толилуулгын валют бүртгэлийн валютаас өөр байвал тэрээр үр дүн, санхүүгийн байдлаа толилуулгын валют уруу хөрвүүлэх ба үүссэн ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.

толилуулна. Аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг болон санхүүгийн тайланг толилуулгын валют руу хэрхэн хөрвүүлэх, үүсэх ханшийн зөрүүг бүртгэхэд НББОУС 21 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* – ийг мөрдөнө.

6. Эздийн өмчийн бусад хэсэг

Энэ хэсэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзын¹² дүнг толилуулна.

7. Хуримтлагдсан ашиг

Компанийн үүсэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд компанид хуримтлагдан үлдсэн ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

Гуравдугаар бүлэг: ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын дэлгэрэнгүй тайлан нь аж ахуйн нэгжийн тодорхой хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмжинэ. Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг хүлээн авсан эсхүл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Орлоготой холбогдож гарсан борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон бусад зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана. Энэхүү тайланд зардлыг чиг үүргээр нь ангилж үр дүнг тооцно.

Орлогын дэлгэрэнгүй тайланг бэлтгэх

- (а) Орлогын дэлгэрэнгүй тайланг бэлтгэхдээ тухайн тайлант үед хамрагдах орлого, зардлын ажил гүйлгээг аккруэл зарчмаар бүртгэнэ;
- (б) Орлого ба зардлыг тэдгээрийн үүсэн гарч буй шалтгаанаар нь ангилна. Орлогын зүйл анги тус бүрт зардлын зүйл ангийг зохицуулах зарчмыг баримтлан бүртгэнэ;
- (в) Бизнесийн тодорхой чиглэлүүдээр зардлын зүйл ангийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, мэдээлэх ажлыг өртгийн бүртгэлийн хүрээнд зохион байгуулна;
- (г) Борлуулалтын орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бизнесийн үндсэн чиглэл тус бүрээр үзүүлнэ.

Дараах дүн бүхий зүйлүүдийг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана. Үүнд:

1. Борлуулалтын орлого

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн буюу гадагш үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого зэрэг байнгын, тогтмол үйл ажиллагаанаас олсон орлогыг борлуулалтын хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр нь орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана.

Аж ахуйн нэгж ямар төрлийн орлого олж байгаагаас шалтгаалан борлуулалтын орлогыг үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж “үйлчилгээний орлого”, үйлдвэрлэл, худалдааны чиглэлийн аж ахуйн нэгж “бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлого” гэж нэрлэнэ. Санхүүгийн тайлангийн тодруулгад борлуулалтын орлогын бүрэлдэхүүн тус бүрийн нийт болон цэвэр дүнг тодруулна.

2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

¹² НББОУС 1 *Санхүүгийн тайлангийн толилуулга* – д заасны дагуу *Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актуар олз, гарз, Санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, Мөнгөн гүйлгээний хейдэж дэх хейдэжийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз* үүнд хамаарна.

Аж ахуйн нэгжийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээс хамаарч борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдааны чиглэлийн аж ахуйн нэгжийн хувьд борлуулсан барааны өртөг, үйлдвэрлэл болон үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн хувьд борлуулсан бүтээгдэхүүний өртөг хамаарна. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг борлуулалтын орлоготой нь уялдуулж санхүүгийн тайланд тодруулна.

3. Нийт ашиг

Борлуулалтын орлогоос борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хасч нийт ашгийг тодорхойлно.

4. Түрээсийн орлого

Түрээслүүлэгчээс түрээслэгчид хөрөнгийг тодорхой хугацаанд, тодорхой төлбөртэйгээр ашиглуулах эрхийг шилжүүлэх тухай гэрээний дагуу түрээслүүлэгчийн хүлээн авах мөнгөн болон мөнгөн бус дүнг түрээсийн орлогод хамруулна. Түрээсийн орлогыг НББОУС 17 *Түрээс* – ийн дагуу бүртгэнэ.

5. Хүүний орлого

Аж ахуйн нэгжийн бүх төрлийн хүүний орлого хамаарна. Хүүний орлогыг татвар суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна.

6. Ногдол ашгийн орлого

Бусад аж ауйн нэгжээс хүлээн авах ногдол ашгийг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрнө. Ногдол ашгийн орлогыг НББОУС 18 *Орлого* – ын дагуу бүртгэж, татвар суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна.

7. Эрхийн шимтгэлийн орлого

Аж ахуйн нэгжийн барааны тэмдэг, зохиогчийн эрх, патент, компьютерийн програм хангамж болон бусад урт хугацаат хөрөнгө ашиглуулсны төлөө бусдаас авах төлбөр хамаарна. Эрхийн шимтгэлийн орлогыг НББОУС 18 *Орлого* – ын дагуу бүртгэж, татвар суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна.

8. Бусад орлого

Дээр дурьдсан орлогуудаас бусад орлогуудыг холбогдох СТОУС – ын дагуу энэ хэсэгт бүртгэнэ.

9. Борлуулалт маркетингийн зардал

Борлуулалт маркетингийн зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Борлуулалт маркетингийн зардлыг цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, зар сурталчилгааны, тээврийн, томилолтын, даатгалын, бичиг хэргийн, шуудан холбооны, элэгдэл хорогдлын зардлууд болон бусад гэж дэлгэрэнгүй тодруулна.

10. Ерөнхий ба удирдлагын зардал

Ерөнхий ба удирдлагын зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Ерөнхий ба удирдлагын зардлыг ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй судалгааны¹³ болон хөгжүүлэлтийн¹⁴ зардал болон бусад гэж тодруулна.

¹³ НББОУС 38 *Биет бус хөрөнгө*- д заасны дагуу судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө. Судалгааны зардалд шинэ мэдлэг эзэмших зорилготой үйл ажиллагаа, судалгааны үр дүнг үнэлэх, ижил төрлийн аль эсхүл сайжруулсан материал, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны эрэл хайгуул хийх, үнэлэх, томъёолох, бүтээн байгуулахтай холбоотой зардлууд хамаарна.

11. Санхүүгийн зардал

Үүнд бүх төрлийн хүүний зардал хамаарна.

12. Бусад зардал

Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардлын ангилалд ороогүй бусад зардлууд орно. Тухайлбал, хандивийн зардал, алданги, торгуулийн зардал, найдваргүй авлагын зардал болно.

13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр, авлага, төлөгдөөгүй зээл, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийгдсэн ханшийн тэгшитгэлийн валютын ханшийн зөрүүний олз (гарз), зарим мөнгөн бус зүйлсийн валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн олз (гарз)-ыг хамруулна. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ыг НББОУС 21 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* – ийн дагуу бүртгэнэ.

14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)

Үндсэн хөрөнгийг түүнийг борлуулах, хандивлах эсхүл түүний ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж хүртэхгүй болсон үед данснаас хасна. Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон хасалтаас олсон орлогын зөрүүгээр олз (гарз)-ыг тодорхойлно.

15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)

Биет бус хөрөнгийг актлах, борлуулах, хандивлах болон бусад хэлбэрээр данснаас хасах үед дансны үнэ болон хасалтаас олсон орлогын зөрүүгээр олз (гарз)-ыг тодорхойлно.

16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)

Бүх төрлийн хөрөнгө оруулалт борлуулсны олз, гарз хамаарна.

17. Бусад ашиг (алдагдал)

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс аль эсхүл данснаас хасахад үүссэн олз (гарз), дахин үнэлсэн хөрөнгийн ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз (гарзын буцаалт), ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний олз (гарз) хамаарна.

18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)

Нийт ашгийн дүн дээр түрээсийн орлого, хүүний орлого, ногдол ашгийн орлого, эрхийн шимтгэлийн орлого, бусад орлогыг нэмж, түүнээс борлуулалт маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардлыг хасч, гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз), үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз), биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз), хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз), бусад ашиг (алдагдал)-ийг нэмж (хасч) татвар төлөхийн өмнөх ашгийг тодорхойлно.

19. Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал (орлого) нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардал (орлого) – аас бүрдэнэ. Тайлант үеийн татварын зардал гэдэгт нийтлэг болон тусгай хувь хэмжээгээр ногдуулсан ААНОАТ-ын нийт дүн орно.

¹⁴ Хөгжүүлэлтийн зардалд үйлдвэрлэлийн өмнөх загварыг төлөвлөх, зохион бүтээх, турших, шинэ технологийг багтаасан тоног төхөөрөмж зохион бүтээх, шинэ эсхүл сайжруулсан материал, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процесс төлөвлөх, зохион бүтээх, туршихтай холбоотой зардлууд хамаарах бөгөөд НББОУС 38 *Биет бус хөрөнгө* -д заасан шалгуур хангагдахгүй тохиолдолд биет бус хөрөнгөөр бус тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)

Аж ахуйн нэгжийн өнөөгийн болон ирээдүйд хэрэгжүүлэх ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) – ийг татвар төлөхийн өмнөх ашгаас орлогын татварын зардлыг хасч тодорхойлно.

21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)

СТОУС 5 *Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* – д заасны дагуу зогсоосон үйл ажиллагаа гэдэгт аж ахуйн нэгжийн борлуулах гэж буй тусдаа томоохон үйл ажиллагааны чиглэл эсвэл үйл ажиллагаа явуулах газар зүйн бүс нутгийн төлөөлөл, дахин борлуулах зорилгоор худалдан авч эзэмшсэн охин компани хамаарна.

Орлогын дэлгэрэнгүй тайланд зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал), зогсоож буй үйл ажиллагааг илэрхийлэх хөрөнгө (аль эсвэл бүлэг хөрөнгө) – ийн борлуулалтаас хүлээн зөвшөөрсөн татварын дараах олз (гарз) - ын нийлбэр дүнг *Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)* гэж толилуулна.

22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)

Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) болон зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) – ийн нийлбэр дүнгээр тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) – ийг тооцно.

23. Бусад дэлгэрэнгүй орлого

Бусад дэлгэрэнгүй орлогод ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй дараах олз (гарз)-ыг хамруулна. Үүнд:

- (а) Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү: үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү (өсөлт буюу бууралт), дахин үнэлсэн үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй үнэ цэнийн бууралтын гарз, гарзын буцаалт;
- (б) Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү: аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг болон аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүү;
- (в) Бусад олз, гарз: санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн олз (гарз), мөнгөн гүйлгээний хейдж дэх хейджийн хэрэглүүрээс үүссэн бодит үнэ цэнийн олз (гарз), ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн актуар олз, гарз, дахин ангиллын тохируулга¹⁵ үүнд хамаарна.

24. Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй орлого

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) болон бусад дэлгэрэнгүй орлогын нийлбэр дүнгээр нийт дэлгэрэнгүй орлогыг тооцно.

25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)

Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлын хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцно.

Толгой компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь

¹⁵ НББОУС 1 *Санхүүгийн тайлангийн толилуулга* – д заасны дагуу өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн зарим олз, гарзыг тухайн тайлант үед ашиг, алдагдалд ангилсан бол тэр дахин ангилсан дүнг дахин ангиллын тохируулга гэж нэрлэж бусад дэлгэрэнгүй орлогоос хасна.

ашгийг тодорхойлно. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ийг бүртгэхэд НББОУС 33 *Нэгж хувьцаанд ногдох ашиг* – ыг мөрдөнө.

Дөрөвдүгээр бүлэг: ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайланд эздийн өмчид гарсан аливаа өөрчлөлтийн хэмжээг дараах байдлаар хоёр жилээр толилуулна. Үүнд:

1. Эздийн өмчийн бүрэлдэхүүн тус бүрийн хувьд тайлант үеийн эхний болон эцсийн үлдэгдэл нь тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал), бусад дэлгэрэнгүй орлого, өмчид гарсан өөрчлөлт, хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-дэд хуваарилсан ногдол ашиг, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдэл зэрэг эздийн өмчид гарсан аливаа өөрчлөлтийг тусгасан байна;
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгыг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулж тусгана;
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)-ийн дүнг хуримтлагдсан ашиг (алдагдал)-ийн залруулсан үлдэгдлийн дүн дээр нэмнэ;
4. Бусад дэлгэрэнгүй орлогын дүнг бүрэлдэхүүн тус бүрээр задлан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, эздийн өмчийн бусад хэсгийн өмнөх тайлант үеийн үлдэгдэл тус бүр дээр нэмнэ;
5. Өмчид гарсан өөрчлөлт гэдэг нь тухайн тайлант үед нэмж гаргасан хувьцаа, буцаан худалдан авсан хувьцаа, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгөнд гарсан өөрчлөлт байна. Өмчид гарсан өөрчлөлтийн дүнг дараах байдлаар тусгана:
 - (а) Нэмж гаргасан хувьцаа, нэмж оруулсан хөрөнгө, хүчингүй болсон хувьцаа, буцаан татан авсан хөрөнгийн дүнг өмнөх тайлант үеийн өмчийн үлдэгдэл дээр (үлдэгдлээс) нэмж (хасч) харуулна;
 - (б) Буцаан худалдан авсан хувьцааны дүнгээр халаасны хувьцааны дүнг нэмэгдүүлнэ;
 - (в) Нэмж хувьцаа гаргах, хувьцаа буцаан худалдан авах, хувьцаа хүчингүй болгоход үүссэн нэмж төлөгдсөн капитал дансны өсөх (буурах) өөрчлөлтийн дүнг өмнөх тайлант үеийн нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдэл дээр (үлдэгдлээс) нэмнэ (хасна);
 - (г) Нэмж хувьцаа гаргах зардал болон хувьцаа буцаан худалдан авах, хүчингүй болгох ажил гүйлгээнээс үүсэх хуримтлагдсан ашиг дансны буурах өөрчлөлтийг хуримтлагдсан ашиг дансны залруулсан үлдэгдлээс хасна.
6. Зарласан ногдол ашгийн дүнг хуримтлагдсан ашиг дансны залруулсан үлдэгдлээс хасна;
7. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг данснаас хасах үед тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийн дүнг дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн гэсэн мөрөнд хуримтлагдсан ашгаас хасч тусгана;
8. Хуримтлагдсан ашиг (алдагдал) – ийн залруулсан үлдэгдэл дээр тайлант үеийн цэвэр ашиг, өмчид гарсан нэмэгдэх өөрчлөлт, дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүнг нэмж, тайлант үеийн цэвэр алдагдал, өмчид гарсан хасагдах өөрчлөлт болон зарласан ногдол ашгийг хасч тайлант үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал) –ийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно;

9. Нийт эздийн өмчийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийг нэмж, нийт хасагдсан өөрчлөлтийг хасч, эздийн өмчийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

Тавдугаар бүлэг: МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөнгөн гүйлгээний тайлан нь үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ, бүх цэвэр мөнгөн гүйлгээ гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд хоёр жилээр зэрэгцүүлэн дараах байдлаар харуулна. Үүнд:

- (a) Мөнгөн хөрөнгийг бүрдүүлсэн эх үүсвэрийг мөнгөн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг мөнгөн зарлага гэсэн хэсэгт үзүүлнэ;
- (б) Үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр нийт цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно;
- (в) Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасч тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайлангийн “Бүх цэвэр мөнгөн гүйлгээ” гэсэн дүнтэй тэнцүү байна;
- (г) Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэхэд шууд аргыг хэрэглэнэ.

1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

- (a) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогод:
 - Борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний орлого;
 - Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого;
 - Даатгалын нөхөн олговроос хүлээн авсан мөнгө;
 - Буцаан авсан албан татвар ;
 - Улсаас авсан татаас, санхүүжилт;
 - Бусад мөнгөн орлого орно.
- (б) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:
 - Ажиллагчдад төлсөн;
 - Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн;
 - Бараа материал худалдан авахад төлсөн;
 - Ашиглалтын зардалд төлсөн;
 - Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн;
 - Хүүний төлбөрт төлсөн¹⁶;
 - Татварын байгууллагад төлсөн;
 - Даатгалын төлбөрт төлсөн мөнгө;
 - Бусад мөнгөн зарлага орно.

¹⁶ Тухайн аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны төрлөөс хамаарч төлсөн болон хүлээн авсан хүү, ногдол ашгийг үндсэн, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны аль нэгээр ангилж, энэхүү ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөнө.

- (в) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно.

2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

- (а) Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь хөрөнгө оруулалт, урт хугацаат хөрөнгө олж эзэмших, борлуулах, бусдад зээл болон мөнгөн урьдчилгаа олгох, тэдгээрийн буцаан төлөлтөөс бий болсон мөнгөн гүйлгээг харуулна.
- (б) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогод:
- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө (тухайлбал ХОЗҮХХ, бусад санхүүгийн хөрөнгө) борлуулснаас;
 - Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт борлуулснаас;
 - Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс (санхүүгийн байгууллагын хувьд олгосон зээл, мөнгөн урьдчилгаа нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд хамаарна);
 - Мөнгөөр хүлээн авсан хүү;
 - Мөнгөөр хүлээн авсан ногдол ашиг орно.
- (в) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагад:
- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө;
 - Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө;
 - Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа орно.
- (г) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

- (а) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь аж ахуйн нэгжид санхүүжилт олгосон этгээд ирээдүйд хэдий хэмжээний төлбөр нэхэмжлэх вэ гэдгийг урьдчилан тооцох боломжийг илэрхийлдэг.
- (б) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогод:
- Банкнаас авсан урт болон богино хугацааны зээл, бүх төрлийн өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө;
 - Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө орно.
- (в) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:
- Зээл, өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгө, урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт;
 - Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн ;
 - Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн;
 - Мөнгөөр төлсөн ногдол ашиг орно.
- (г) Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант оны эхний, эцсийн үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө дансны эхний, эцсийн үлдэгдлийн дүнтэй тэнцүү байна.

Зургадугаар бүлэг: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлангийн тодруулгад үндсэн болон туслах үйл ажиллагааны чиглэл, салбар болон төлөөлөгчийн газрын нэр, байршил, санхүүгийн тайлангийн огноо, хамарсан тайлант хугацааг тодруулахаас гадна дараах мэдээллийг системтэй арга хэлбэрээр харуулна. Үүнд:

1. Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлан нь СТОУС-д нийцсэн тухай мэдэгдэл, санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар бэлтгэсэн эсэх, санхүүгийн тайлангийн суурь, толилуулгын валют, тайлант хугацаанд мөрдсөн НББОУС болон СТОУС-ыг товч тодорхойлж бичнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

Энэ хэсэгт нягтлан бодох бүртгэлийн бодлогын¹⁷ өөрчлөлт, алдаа болон тооцооллын өөрчлөлтийн талаар НББОУС 8 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа* – д заасны дагуу тодруулна.

(а) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт¹⁸

Хэрэв аж ахуйн нэгж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн¹⁹ бол өөрчлөх болсон шалтгаан, өөрчлөлтийн мөн чанар, шилжилтийн нөхцлийн тодорхойлолт, тайлбар, нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг найдвартай ба илүү хамааралтай мэдээллээр хангана гэж үзсэн шалтгаан, санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөө зэргийг тодруулна.

(б) Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт

Аж ахуйн нэгж нь НББОУС 8 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа* – д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг гүйцээн мөрдөх горимын дагуу хүлээн зөвшөөрч түүний мөн чанар, тайлант үед үзүүлсэн нөлөө, ирээдүйн тайлант үед үзүүлэх нөлөө зэргийг тооцоолох практик боломжгүй байхаас бусад тохиолдолд тодруулна.

(в) Нягтлан бодох бүртгэлийн алдаа

Аж ахуйн нэгжийн өмнөх тайлант үеийн материаллаг алдааг тухайн алдааг илрүүлсэн тайлант үеийн санхүүгийн тайланд буцаан мөрдөх горимын дагуу залруулна. НББОУС 8 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа* – д заасны дагуу тодруулна.

3. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс, харилцах дансанд байгаа мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдлийг тодруулна.

¹⁷ Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахад мөрдлөг болгодог, тухайн аж ахуйн нэгжийн зүгээс боловсруулан гаргасан тусгай зарчим, суурь, дүрэм, журам, заавар, аргачлал ба практик үйл ажиллагаа юм.

¹⁸ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаан мөрдөх горимын дагуу өмнөх үе рүү буцаан мөрдвөл нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг анхнаас нь хэрэглэж байсан мэтээр хамгийн эхний өмнөх тайлант үед толилуулсан өмчийн дансны бүрэлдэхүүн бүрийн эхний үлдэгдэл ба өмнөх тайлант үе бүрт тодруулсан бусад зэрэгцүүлэгдэх дүнг тохируулна.¹⁸

¹⁹ Тухайлбал, бараа материалын өртөг тооцох аргыг өөрчлөх нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт юм.

4. Дансны болон бусад авлага

Энэ хэсэгт дансны, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн болон бусад авлагыг тодруулна.

4.1 Дансны авлага

Дансны авлага, найдваргүй авлагын хасагдуулга дансдын эхний болон эцсийн үлдэгдэл, тухайн тайлант хугацаанд нэмэгдсэн болон хасагдсан (төлөгдсөн, найдваргүй болж хасагдсан) авлагын дүн, санхүүгийн байдлын тайланд толилуулсан дансны авлагын дансны цэвэр дүнг тодруулна. Дансны авлагын төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, найдваргүй гэж ангилсан дүн, найдваргүй авлагын хасагдуулга байгуулсан аргыг тэмдэглэл хэсэгт тодруулна.

4.2 Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн бүх төрлийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүнг дэлгэрэнгүй тодруулна. Албан татварын авлагыг ААНОАТ-ын, НӨАТ-ын болон бусад татвар, төлбөр, хураамжийн төрлөөр харуулна.

4.3 Бусад авлага

Холбоотой талаас авах авлага (тайлант хугацаанд хамаарах дүн), ажиллагчдаас авах авлага, ногдол ашиг, хүү, богино хугацаат авлагын бичгийн авлага, бусад байгууллага, хувь хүнээс авах авлага гэж нэр төрлөөр нь тодруулна.

5. Бусад санхүүгийн хөрөнгө (эргэлтийн хөрөнгө)

Эргэлтийн хөрөнгийн хэсэг дэх бусад санхүүгийн хөрөнгийн бүрэлдэхүүн тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдлийг СТОУС 7 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга* –ийн дагуу тодруулна.

6. Бараа материал

Бараа материалыг түхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бараа, бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материал болон бусад гэж ангилан, эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд нэмэгдсэн (худалдан авсан, үйлдвэрлэсэн), хасагдсан (борлуулсан, ашигласан) дүн, үнийн бууралт, бууралтын буцаалтын дүнг тус тус тодруулна.

Бараа материалын өртгийг тодорхойлоход хэрэглэсэн (жинлэсэн дундаж өртгийн, эхэлж авснаа эхэлж зарлагадах, тусгай тэмдэглэгээний) арга, бараа материалын бүртгэлийн систем, өртөг болон цэвэр боломжит үнийн аль багыг сонгох арга, гадаад валютаар илэрхийлэгдсэн бараа материалын дүн зэргийг тэмдэглэл хэсэгт тодруулна.

Үнийн бууралт нь бараа материалын хуучрал, гэмтэл, иж бүрдлийн болон борлуулалтын зардлын өсөлт, борлуулалтын үнийн бууралт болон бусад шалтгаанаар үүснэ. Аж ахуйн нэгж нь бараа материалын үнийн бууралтыг тооцох аргачлалыг боловсруулж тайлант үе бүрт тууштай мөрдөнө.

НББОУС 2 *Бараа материал* – д заасны дагуу бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрт шинэчлэн тогтооно. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулсан дүн болон бусад гарзыг тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Цэвэр боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүсэх үнийн бууралтын буцаалтыг тухайн буцаах бичилт гарсан тайлант үе дэх зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүнгийн бууралт гэж бүртгэнэ.

7. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Урьчилгаа төлбөрүүдийн төрөл тус бүрээр тодруулна.

8. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) болон өр төлбөр

СТОУС 5 *Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* – д заасны дагуу тодруулна.

9. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн анги тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан дүн, хуримтлагдсан элэгдэл дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна. Үндсэн хөрөнгийн зүйлийг дахин ангилсан бол тодруулна. Үндсэн хөрөнгийн дансны цэвэр дүнг хөрөнгө тус бүрээр харуулна. Тэмдэглэл хэсэгт дансны үнийг тодорхойлоход ашигласан суурь, элэгдэл тооцсон арга, дахин үнэлгээний талаарх мэдээллийг тодруулна.

10. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн анги тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан дүн, хуримтлагдсан хорогдол дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа (хэрэв ашиглалтын тодорхой хугацаагүй бол энэ талаар тодруулна), хорогдуулгын хувь, хорогдол тооцсон арга, дахин үнэлгээний талаарх болон бусад мэдээллийг тодруулна.

11. Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга гэсэн зүйл ангиар бүртгэсэн баригдаж буй барилгатай холбоотой гарсан шууд материал, шууд хөдөлмөр болон нэмэгдэл зардлуудын хуримтлагдсан дүн, барьж эхэлсэн огноо, дуусгалтын хувь болон бусад мэдээллийг тодруулна.

12. Биологийн хөрөнгө

НББОУС 41 *Хөдөө аж ахуй* - д заасан тодруулгыг хийнэ.

13. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын төрөл, дүн, бий болсон олз, гарзын дүнг тодруулна. Охин компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг НББОУС 27 *Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан* – ийн дагуу тодруулна.

14. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө²⁰

НББОУС 40 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* – д заасны дагуу тодруулна.

15. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Бусад эргэлтийн бус хөрөнгийн бүрэлдэхүүн тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдлийг тодруулж, тайлбар, тэмдэглэл хийнэ.

16. Өр төлбөр

²⁰ Аж ахуйн нэгж нь НББОУС 17 *Түрээс* болон НББОУС 40 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* – д заасан тодруулгуудыг бэлтгэнэ.

16.1 Дансны өглөг

Дансны өглөгийн төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн гэж ангилсан дүнг тодруулна.

16.2 Татварын өр

ААНОАТ-ын, НӨАТ-ын, ХХОАТ-ын, ОАТ-ын болон бусад татвар, төлбөр, хураамжийн өрийг тодруулна.

16.3 Банкны богино хугацаат зээл

Төгрөгөөр болон гадаад валютаар авсан банкны богино хугацаат зээлийн эхний болон эцсийн үлдэгдлийг зээлийн ангилал, үзүүлэлт тус бүрээр тодруулна.

16.4 Богино хугацаат нөөц

Богино хугацаат нөөцийн ангилал бүрээр эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны нөөцийн өсөлт, тайлант үед ашигласан нөөцийн дүн, тайлант үед ашиглаагүй буцаан бичсэн нөөцийн дүнг тодруулна. Тэмдэглэл хэсэгт урт хугацаат нөөцийн дүнг тодруулж бусад тайлбарыг хийнэ.

16.5 Бусад богино хугацаат өр төлбөр

Бусад богино хугацаат өр төлбөрийн төрлөөр эхний болон эцсийн үлдэгдэл, гадаад валютаар илэрхийлэгдсэн дүнг тодруулна.

16.6 Урт хугацаат зээл ба бусад өр төлбөр

Урт хугацаат зээлийг дотоодын эх үүсвэрээс авсан, гадаадын эх үүсвэрээс шууд болон дамжуулан зээлдсэн, гадаад болон дотоодын зах зээлд гаргасан урт хугацаат бонд, өрийн бичгийн дүн, хэрэв нэгээс дээш төрлийн дотоодын болон гадаадын зээл авсан бол тус бүрийг нь тодруулна.

17 Эздийн өмч

17.1 Өмч

НББОУС 1 *Санхүүгийн тайлангийн толилуулга* – д заасны дагуу компаниудын хувьд энгийн болон давуу эрхтэй хувьцааны тоо ширхэг, эхний болон эцсийн үлдэгдэл, өмч (хувьцаат капитал буюу хувь нийлүүлэгчдийн хөрөнгө) – ийн дүнд тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг тодруулна. Тэмдэглэл хэсэгт өмчийн дүнд орсон өөрчлөлтийн эрх зүйн үндэслэл, энгийн болон давуу эрхтэй хувьцааны нэрлэсэн үнэ, эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо, халаасны хувьцааг бүртгэх арга, төлбөр нь бүрэн төлөгдөөгүй энгийн хувьцааны талаар тодруулна.

17.2 Хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч) - ийн мэдээлэл

Том хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч) хуулийн этгээд, хувь хүний нэр, хувь эзэмшлийн хэмжээний талаарх мэдээллийг тодруулна.

17.3 Нэмж төлөгдсөн капитал

Нэмж төлөгдсөн капитал дансны дүнг энгийн хувьцааны, давуу эрхтэй хувьцааны, халаасны хувьцааны гэж тодруулна.

17.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Энэхүү дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийн дүнг тодруулна.

17.5 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс, бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн валютын хөрвүүлэлтийн зөрүүг тодруулна.

17.6 Эздийн өмчийн бусад хэсэг

“Эздийн өмчийн бусад хэсэг” – ийн бүрэлдэхүүн тус бүр (тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актуар олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, мөнгөн гүйлгээний хейдж дэх хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз) - ийн дүнг тодруулна.

18. Борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Байнгын, тогтмол үйл ажиллагаанаас бий болсон орлогыг нэр төрлөөр нь бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого, ажил, үйлчилгээ борлуулсны орлого гэж ангилна. Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралтын дүнг тодруулна.

Борлуулалтын орлоготой нь уялдуулж борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өмнөх болон тайлант оны дүнг тодруулна.

19. Бусад орлого, олз (гарз), ашиг (алдагдал)

19.1 Бусад орлого

Орлогын дэлгэрэнгүй тайланд толилуулсан бусад орлогын дүнд хамаарах орлогыг тодруулна.

19.2 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн валютын ханшийн зөрүүний олз (гарз) – ыг гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, гадаад валютаар илэрхийлэгдсэн богино болон урт хугацаат өр төлбөр, авлагын үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэлийн олз, гарз гэж тодруулна.

19.3 Бусад ашиг (алдагдал)

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс эсхүл данснаас хасахад үүсэн олз (гарз), хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн), хөрөнгийн дахин үнэлгээний олз (гарз) болон бусад ашиг, алдагдлыг тодруулна.

20. Зардал

20.1 Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал

Ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын, зар сурталчилгааны зардлуудыг борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын гэж ангилж тайлант оны болон өмнөх оны дүнг тодруулна.

20.2 Бусад зардал

Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардлын ангилалд хамрагдахгүй алданги, торгуулийн зардал, найдваргүй авлагын зардал, хандивийн болон бусад зардлыг энэ хэсэгт тодруулна.

20.3 Цалингийн зардал

Цалингийн зардал болон ажиллагчдын дундаж тоог үйлдвэрлэл, үйлчилгээний, борлуулалт маркетингийн, ерөнхий ба удирдлагын гэж ангилж тайлант оны болон өмнөх оны дүнг тодруулна.

21 Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал (орлого) – ын тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого) – ын дүнг тодруулна.

22 Холбоотой талуудын тодруулга

НББОУС 24 *Холбоотой талуудын тодруулга* – д заасны толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь ялгаатай бол тэрхүү хяналт тавигч компани, хувь хүний нэрийг, тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд²¹ олгосон урт болон богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг тодруулна.

23. Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

НББОУС 37 *Нөөц, Болзошгүй өр төлбөр ба Болзошгүй хөрөнгө* - ийн дагуу аж ахуйн нэгж нь тайлангийн өдрийн байдлаарх хэрэгжих магадлалтай болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн мөн чанар, хэрэв практик боломжтой бол тэдгээрийн санхүүгийн нөлөөний тооцооллыг тодруулна.

24. Тайлагналын үеийн дараах үйл явдал

НББОУС 10 *Тайлагналын үеийн дараах үйл явдал* – ын дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцооллыг тодруулна. Хэрэв санхүүгийн нөлөөллийн тооцоолол хийх боломжгүй бол тайлбар, тэмдэглэл хийнэ.

25. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашгийн болон бусад зардал

Энэ тодруулгыг ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж гаргана.

25.1 Аж ахуйн нэгжийн улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлсөн ногдол ашиг, яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн хураамж, үйлчилгээний хөлс, бусад зардлыг хүснэгтэд заасны дагуу ялган харуулна.

25.2 Аж ахуйн нэгжийн орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, орон нутгийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төлсөн ногдол ашиг, нутгийн захиргааны байгууллагад төлсөн хураамж, үйлчилгээний хөлс, бусад зардлыг хүснэгтэд заасны дагуу ялган харуулна.

25.3 Бусад зардал гэдэгт дараах зүйлс хамаарна. Үүнд:

1. Байгаль хамгаалах зардлын урьдчилгаа гэдэгт “Ашигт малтмалын тухай хууль” – д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан дүнг тодруулна.

²¹Тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүн гэж аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шууд болон шууд бусаар төлөвлөх, удирдах, хянах эрх, үүрэг бүхий хүмүүс болон аж ахуйн нэгжийн гүйцэтгэх болон бусад захирлуудыг хэлнэ.

2. Бусад байгууллагад өгсөн хандив, дэмжлэг гэдэгт “Төсвийн тухай” хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу үзүүлсэн мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэгийн дүнг байгууллага тус бүрээр тодруулна.

26. Хөрөнгө оруулалтын мэдээ

Аж ахуйн нэгж нь тайлант хугацаанд хийсэн хөрөнгө оруулалтыг энэ хүснэгтийн дагуу тодруулна.

Хөрөнгө оруулалт гэж аж ахуйн нэгжийн хуримтлалыг шинээр бий болгох, түүний техникийн зэвсэглэмжийг дээшлүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө, хайгуул, зураг төсвийн ажлын зардлыг хэлнэ.

Аж ахуйн нэгж нь тайлант хугацаанд бий болсон, худалдаж авсан биет болон биет бус хөрөнгө, хайгуул, үнэлгээний хөрөнгийг эх үүсвэр бүр (өөрийн хөрөнгөөр, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, банкны зээлээр, гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээл, буцалтгүй тусламжаар, төсөл, хөтөлбөр, хандивийн хүрээнд болон бусад эх үүсвэр) - ээр тодруулна.

Биет хөрөнгө гэдэгт аж ахуйн нэгжийн санхүүгийн байдлын тайланд тусгасан үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө, эргэлтийн бус биологийн хөрөнгө болон бусад биет хөрөнгийг (тухайлбал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө) хамруулна. Барилга, байгууламжийн²² дүнд багтсан орон сууцны барилга²³, авто замын²⁴ дүнг тусад нь тодруулна. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дүнг тусад нь тодруулна.

Биет бус хөрөнгө гэдэгт санхүүгийн байдлын тайланд тусгасан биет бус хөрөнгөнд хамаарах хөрөнгө орно. Компьютерийн програм хангамжийг дотор нь програм хангамж, мэдээллийн сан гэж ангилна.

Бусад биет бус хөрөнгөнд хамаарах барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардлыг тусад нь тодруулна.

Геологи уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн олж эзэмшсэн хайгуул үнэлгээний хөрөнгийг биет, биет бус хөрөнгө гэж ангилж тусад нь тодруулна.

Нийт дүнд биет хөрөнгө, биет бус хөрөнгө, хайгуул үнэлгээний хөрөнгийн нийлбэрийг дүгнэнэ.

²² Үйлдвэрлэл, худалдаа, нийтийн үзвэр, үйлчилгээний барилга, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга гэх мэт бүх төрлийн барилга болон авто зам, гудамж, онгоцны нислэгийн зам, гүүр, өргөгдсөн зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, далан, хол зайд тавигдсан хоолой, холбооны болон эрчим хүчний шугам, кабель болон бусад шугам, олборлох, боловсруулах үйлдвэрийн байгууламж; спорт, амралтын байгууламж хамаарна.

²³ Хүн суурин амьдардаг орон сууцны зориулалттай барилга, оршин суугчдад зориулж суурилуулсан байгууламж, гараж зэргийг хамруулна.

²⁴ Авто замд авто зам, гудамж, онгоцны нислэгийн зам, өргөгдсөн зам, туннель зэрэг орно.

Регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--

Хаяг : _____

Шуудангийн хаяг : _____

Утас : _____ Факс : _____

Өмчийн хэлбэр : Төрийн хувь хувийн хувь.

.....-ИЙН
 ОНЫ - Р УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг

.....-ийн
..... оны санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл

..... оны сарын өдөр

Захирал _____, ерөнхий нягтлан бодогч
_____ бид манай аж ахуйн нэгжийн оны сарын-
ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр
дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн
зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн
нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн
хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны
ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон
улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг
бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Захирал _____ /...../

Ерөнхий нягтлан бодогч _____ /...../

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

20.... оны сарын өдөр

(Аж ахуйн нэгжийн нэр)

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.12	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

20.... оны сарын өдөр

(Аж ахуйн нэгжийн нэр) _____

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг		
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн		
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		

Захирал _____ (.....)

Ерөнхий нягтлан бодогч _____ (.....)

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

20.... оны сарын өдөр

(Аж ахуйн нэгжийн нэр)

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		
19	Орлогын татварын зардал		
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Захирал _____ (.....)

Ерөнхий нягтлан бодогч _____ (.....)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

20... оны ... сарын өдөр
/төгрөгөөр/

(Аж ахуйн нэгжийн нэр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20... оны 01-р сарын 01-ний үлдэгдэл								
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)								
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	20... оны ... -р сарын ... -ний үлдэгдэл								
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)								
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт								
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
17	20... оны ... -р сарын ... -ний үлдэгдэл								

Захирал _____ (.....)

Ерөнхий нягтлан бодогч _____ (.....)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

20... оны сарын өдөр

(Аж ахуйн нэгжийн нэр)

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн		
	Ажиллагчдад төлсөн		
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
	Бараа материал худалдан авахад төлсөн		
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Захирал _____ (.....)

Ерөнхий нягтлан бодогч _____ (.....)

3. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

№	Мөнгөн хөрөнгийн зүйлс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Касс дахь мөнгө		
2	Банкин дахь мөнгө		
3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө		
4	Нийт дүн		

Тэмдэглэл. (Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ).

4. ДАНСНЫ БОЛОН БУСАД АВЛАГА

4.1 Дансны авлага

№	Үзүүлэлт	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулга	Дансны авлага (цэвэр дүнгээр)
1	Эхний үлдэгдэл			
2	Нэмэгдсэн			
3	Хасагдсан:			
	-Төлөгдсөн			
	- Найдваргүй болсон			
4	Эцсийн үлдэгдэл			

4.2 Татвар, нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) - ийн авлага

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ-ын авлага		
2	НӨАТ-ын авлага		
3	НДШ – ийн авлага		
4			
5	Нийт дүн		

4.3 Бусад богино хугацаат авлага (төрлөөр нь ангилна)

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн		
2	Ажиллагчдаас авах авлага		
3	Ногдол ашгийн авлага		
4	Хүүний авлага		
5	Богино хугацаат авлагын бичиг		
6	Бусад талуудаас авах авлага		
7			
8	Нийт дүн		

Тэмдэглэл. (Дансны авлагыг төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, төлөгдөх найдваргүй гэж ангилна. Найдваргүй авлагын хасагдуулга байгуулсан арга, гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагын талаар болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ).

5. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ (ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ)

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1			
2			
3	Нийт дүн		

6. БАРАА МАТЕРИАЛ

№	Үзүүлэлт	Бараа материалын төрөл						Нийт дүн
		Түүхий эд материал	Дуусаагүй үйлдвэрлэл	Бэлэн бүтээгдэхүүн	Бараа	Хангамжийн материал		
1	Эхний үлдэгдэл (өртгөөр)							
2	Нэмэгдсэн дүн							
3	Хасагдсан дүн							
4	Эцсийн үлдэгдэл (өртгөөр)							
5	Үнийн бууралтын гарз (-)							
6	Үнийн бууралтын буцаалт							
7	Дансны цэвэр дүн:							
7.1	Эхний үлдэгдэл							
7.2	Эцсийн үлдэгдэл							

Тэмдэглэл. (Бараа материалын өртгийг тодорхойлоход ашигласан арга, бараа материалын бүртгэлийн систем, гадаад валютаар илэрхийлэгдсэн бараа материалын дүнгийн талаар тайлбар, тэмдэглэл хийнэ).

7. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БҮЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ (ЭСВЭЛ БОРЛУУЛАХ БҮЛЭГ ХӨРӨНГӨ) БОЛОН ӨР ТӨЛБӨР

Тэмдэглэл. (Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолт, хэмжилтийн суурь, борлуулалт хийгдсэн аль эсвэл хийгдэхэд хүргэсэн нөхцөл байдал, борлуулах арга, хугацаа, хүлээн зөвшөөрсөн олз ба гарз болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ).

8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Урьдчилж төлсөн зардал		
2	Урьдчилж төлсөн түрээс		
3	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр		
4			
5	Нийт дүн		

9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Газрын сайжруулалт	Барилга, байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/								
1.1	Эхний үлдэгдэл								
1.2	Нэмэгдсэн дүн								
	Өөрөө үйлдвэрлэсэн								
	Худалдаж авсан								
	Үнэ төлбөргүй авсан								
	Дахин үнэлгээний нэмэгдэл								
1.3	Хасагдсан дүн								
	Худалдсан (-)								
	Үнэгүй шилжүүлсэн (-)								
	Акталсан (-)								
1.4	Үндсэн хөрөнгө дахин ангилсан								
1.5	Үндсэн хөрөнгө, ХОЗҮХХ ²⁵ хооронд дахин ангилсан								
1.6	Эцсийн үлдэгдэл								
2	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ								
2.1	Эхний үлдэгдэл								
2.2	Нэмэгдсэн дүн								
	Байгуулсан элэгдэл								
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн								
	Үнэ цэнийн бууралтын буцаалт								
2.3	Хасагдсан дүн								
	Данснаас хассан хөрөнгийн элэгдэл								
	Дахин үнэлгээгээр хасагдсан								
	Үнэ цэнийн бууралт								
2.4	Эцсийн үлдэгдэл								
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН								
3.1	Эхний үлдэгдэл (1.1 - 2.1)								
3.2	Эцсийн үлдэгдэл (1.6 - 2.4)								

Тэмдэглэл. (Үндсэн хөрөнгийн анги бүрийн хувьд ашигласан хэмжилтийн суурь; элэгдэл тооцох арга; ашиглалтын хугацаа; дахин үнэлсэн бол дахин үнэлгээ хүчинтэй болсон хугацаа, хараат бус үнэлгээчин үнэлсэн эсэх талаар; үндсэн хөрөнгийн дахин ангилал, түүний шалтгаан; бусад тайлбар тэмдэглэлийг хийнэ).

.....

.....

.....

²⁵ Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө.

10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Зохиогчийн эрх	Компьютерийн программ хангамж	Патент	Барааны тэмдэг	Тусгай зөвшөөрөл	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
1	БИЕТ БУС ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/								
1.1	Эхний үлдэгдэл								
1.2	Нэмэгдсэн дүн								
	Өөрөө үйлдвэрлэсэн								
	Худалдаж авсан								
	Үнэ төлбөргүй авсан								
	Дахин үнэлгээний нэмэгдэл								
1.3	Хасагдсан дүн								
	Худалдсан								
	Үнэгүй шилжүүлсэн								
	Акталсан								
1.4	Эцсийн үлдэгдэл								
2	ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ								
2.1	Эхний үлдэгдэл								
2.2	Нэмэгдсэн дүн								
	Байгуулсан хорогдол								
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн								
	Үнэ цэнийн бууралтын буцаалт								
2.3	Хасагдсан:								
	Данснаас хассан хөрөнгийн хорогдол								
	Дахин үнэлгээгээр хасагдсан								
	Үнэ цэнийн бууралт								
2.4	Эцсийн үлдэгдэл								
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН								
3.1	Эхний үлдэгдэл (1.1 - 2.1)								
3.2	Эцсийн үлдэгдэл (1.4 - 2.4)								

Тэмдэглэл. (Биет бус хөрөнгийн анги бүрийн хувьд ашигласан хэмжилтийн суурь, хорогдол тооцох арга, ашиглалтын хугацаа, дахин үнэлсэн бол дахин үнэлгээ хүчинтэй болсон хугацаа, хараат бус үнэлгээчин үнэлсэн эсэх, бусад биет бус хөрөнгийн бүрэлдэхүүн болон бусад тайлбар тэмдэглэлийг хийнэ).

11. ДУУСААГҮЙ БАРИЛГА

№	Дуусаагүй барилгын нэр	Эхэлсэн он	Дуусгалтын Хувь	Нийт төсөвт өртөг	Ашиглалтанд орох эцсийн хугацаа
1					
2					
3	Нийт дүн				

12. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

№	Биологийн хөрөнгийн төрөл	Нас	Хүйс	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
				тоо	дансны үнэ	тоо	дансны үнэ
1							
2	Нийт дүн						

Тэмдэглэл. (Биологийн хөрөнгийн хэмжилтийн суурь болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ).

13. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		Хөрөнгө оруулалтын хувь	Хөрөнгө оруулалтын дүн	Хөрөнгө оруулалтын хувь	Хөрөнгө оруулалтын дүн
1					
2					
3					
4	Нийт дүн				

Тэмдэглэл. (Урт хугацаат хөрөнгө оруулалттай холбоотой бий болсон олз, гарзын дүн, бүртгэсэн аргыг тодруулна. Охин компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг НББОУС 27 Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан – ийн дагуу тодруулна).

14. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Тэмдэглэл. (Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд ашигласан хэмжилтийн суурь; бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз; хэрэв түрээслэдэг бол түрээсийн орлого, түрээслэсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардлууд. Хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон НББОУС 40 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө – д заасны дагуу бусад тодруулгыг хийнэ).

15. БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1			
2			
3	Нийт дүн		

Тэмдэглэл. (Бусад эргэлтийн бус хөрөнгийн төрөл тус бүрээр тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Урт хугацаат авлагыг тодруулна).

16. ӨР ТӨЛБӨР

16.1 Дансны өглөг

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Төлөгдөх хугацаандаа байгаа		
2	Хугацаа хэтэрсэн		
3			
4	Нийт дүн		

16.2 Татварын өр

№	Татварын өрийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ өр		
2	НӨАТ-ын өр		
3	ХХОАТ-ын өр		
4	ОАТ-ын өр		
5	Бусад татварын өр		
6			
7	Нийт дүн		

16.3 Банкны богино хугацаат зээл

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		төгрөгөөр	валютаар	төгрөгөөр	валютаар
1	Төлөгдөх хугацаандаа байгаа				
2	Хугацаа хэтэрсэн				
3					
4	Нийт дүн				

16.4 Богино хугацаат нөөц (өр төлбөр)

№	Нөөцийн төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан (ашигласан нөөц)	Ашиглаагүй буцаан бичсэн дүн	Эцсийн үлдэгдэл
1	Баталгаат засварын					
2	Нөхөн сэргээлтийн					
3						
4	Нийт дүн					

Тэмдэглэл. (Урт хугацаат нөөцийн дүнг тодруулна. Нөөцийн төрлөөр тайлбар, тэмдэглэл хийнэ).

16.5 Бусад богино хугацаат өр төлбөр

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1			
2	Нийт дүн		

Тэмдэглэл. (Гадаад валютаар илэрхийлэгдсэн богино хугацаат өр төлбөрийн дүнг тусад нь тодруулна).

16.6 Урт хугацаат зээл болон бусад урт хугацаат өр төлбөр

№	Төрөл	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		төгрөгөөр	валютаар	төгрөгөөр	валютаар
1	Урт хугацаат зээлийн дүн				
	Гадаадын байгууллагаас шууд авсан зээл				
	Гадаадын байгууллагаас дамжуулан авсан зээл				
	Дотоодын эх үүсвэрээс авсан зээл				
2	Бусад урт хугацаат өр төлбөрийн дүн (гадаад, дотоодын зах зээлд гаргасан бонд, өрийн бичиг)				
3					

Тэмдэглэл. (Урт хугацаат зээл болон бусад урт хугацаат өр төлбөрийн төрлөөр тайлбар, тэмдэглэл хийнэ).

17. ЭЗДИЙН ӨМЧ

17.1 Өмч

№	Үзүүлэлт	Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа		Давуу эрхтэй хувьцаа		Өмчийн дүн (төгрөгөөр)
		Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	
1	Эхний үлдэгдэл					
2	Нэмэгдсэн					
3	Хасагдсан					
4	Эцсийн үлдэгдэл					

Тэмдэглэл. (Өмчийн дүнд орсон өөрчлөлтийн эрх зүйн үндэслэл; энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцааны нэрлэсэн үнэ; тайлант хугацааны турш эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо; хувьцаа буцаан худалдан авсан бол шалтгаан; халаасны хувьцааг бүртгэх арга; төлбөр нь бүрэн төлөгдөөгүй энгийн хувьцааны талаар болон бусад тайлбар, тэмдэглэл хийнэ).

17.2 Хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлэгчдийн мэдээлэл

Тэмдэглэл. (Том хувьцаа эзэмшигч болон хувь нийлүүлэгчдийн нэр, эзэмшлийн хувийг тодруулна).

17.3 Нэмж төлөгдсөн капитал (НТК)

№	Үзүүлэлт	Энгийн хувьцааны НТК	Давуу эрхтэй хувьцааны НТК	Халаасны хувьцааны НТК	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл				
2	Нэмэгдсэн				
3	Хасагдсан				
4	Эцсийн үлдэгдэл				

17.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

№	Үзүүлэлт	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл			
2	Нэмэгдсэн дүн			
	Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
	Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт ²⁶			
3	Хасагдсан дүн			
	Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
	Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз ²⁷			
4	Эцсийн үлдэгдэл			

17.5 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс үүссэн зөрүү				
2	Бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн зөрүү				
3	Бусад				
4	Нийт дүн				

²⁶ Дахин үнэлсэн хөрөнгийн өмнөх тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүнгээс хэтэрсэн дүн.

²⁷ Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээс хэтрэхгүй хэмжээ хүртэл байхаар дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Үлдсэн дүнг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

17.6 Эздийн өмчийн бусад хэсэг

Тэмдэглэл. (Эздийн өмчийн бусад хэсгийн бүрэлдэхүүн тус бүрээр тодруулж тайлбар, тэмдэглэл хийнэ).

18. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Борлуулалтын орлого:		
1.1	Бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого:		
1.2	Ажил, үйлчилгээ борлуулсны орлого:		
1.3	Нийт борлуулалтын орлого		
2	Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт		
3	Цэвэр борлуулалт		
4	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг:		
4.1	Борлуулсан бараа, борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
4.2	Борлуулсан ажил, үйлчилгээний өртөг		
4.3	Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг		

19. БУСАД ОРЛОГО, ОЛЗ (ГАРЗ), АШИГ (АЛДАГДАЛ)

19.1 Бусад орлого

№	Орлогын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1			
2			
3	Нийт дүн		

19.2 Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз

№	Төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн		
2	Авлагын үлдэгдлийн		
3	Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн		
4	Бусад ханшийн зөрүүний ашиг, алдагдал		
5	Нийт дүн		

19.3 Бусад ашиг (алдагдал)

№	Ашиг (алдагдал)	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		
2	ХОЗҮХХ ²⁸ -ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз		
3	ХОЗҮХХ данснаас хассаны олз, гарз		
4	Хөрөнгийн дахин үнэлгээний олз, гарз		
5	Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз (гарзын буцаалт)		
6	Нийт дүн		

20. ЗАРДАЛ

20.1 Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардлууд

№	Зардлын төрөл	Өмнөх оны дүн		Тайлант оны дүн	
		БорМар	ЕрУд	БорМар	ЕрУд
1	Ажиллагчдын цалингийн зардал				
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал				
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал				
4	Томилолтын зардал				
5	Бичиг хэргийн зардал				
6	Шуудан холбооны зардал				
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал				
8	Сургалтын зардал				
9	Сонин сэтгүүл захиалгын зардал				
10	Даатгалын зардал				
11	Ашиглалтын зардал				
12	Засварын зардал				
13	Элэгдэл, хорогдлын зардал				
14	Түрээсийн зардал				
15	Харуул хамгааллын зардал				
16	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал				
17	Тээврийн зардал				
18	Шатахууны зардал				
19	Хүлээн авалтын зардал				
20	Зар сурталчилгааны зардал				
21					
22					
23	Нийт дүн				

²⁸ Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө.

20.2 Бусад зардал

№	Зардлын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Алданги, торгуулийн зардал		
2	Хандивийн зардал		
3	Найдваргүй авлагын зардал		
4			
5	Нийт дүн		

20.3 Цалингийн зардал

Ангилал	Ажиллагчдын дундаж тоо	Цалингийн зардлын дүн	
		Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
Үйлдвэрлэл, үйлчилгээний			
Борлуулалт маркетингийн			
Ерөнхий ба удирдлагын			
Нийт дүн			

21. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Тайлант үеийн орлогын татварын зардал		
2	Хойшлогдсон татварын зардал (орлого)		
3	Орлогын татварын зардал (орлого) – ын нийт дүн		

Тэмдэглэл. (Орлогын татварын зардал (орлого) - ын бүрэлдэхүүн тус бүрээр тайлбар, тэмдэглэл хийнэ).

22. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

22.1 Толгой компани, хамгийн дээд хяналт тавигч компани, хувь хүний талаарх мэдээлэл²⁹

Үзүүлэлт	Толгой компани	Хамгийн дээд хяналт тавигч толгой компани	Хамгийн дээд хяналт тавигч хувь хүн	Тайлбар
Нэр				
Бүртгэгдсэн (оршин суугаа) улс				
Эзэмшлийн хувь				

22.2 Тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд олгосон нөхөн олговрын тухай мэдээлэл

²⁹ НББОУС 24 Холбоотой талуудын тодруулга-д заасны дагуу тодруулна.

Тэргүүлэх удирдлага гэдэгт бүрэлдэхүүнийг хамруулав.³⁰

№	Нөхөн олговрын нэр	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Богино хугацааны тэтгэмж		
2	Урт хугацааны тэтгэмж		
3	Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж		
4	Ажлаас халагдсаны тэтгэмж		
5	Хувьцаанд суурилсан төлбөр		
6	Нийт дүн		

22.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

№	Холбоотой талын нэр	Ажил гүйлгээний утга	Дүн	Тайлбар
1				
2				

23. БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР

Тэмдэглэл. (Болзошгүй хөрөнгө ба өр төлбөрийн мөн чанар, хэрэв практик боломжтой бол тэдгээрийн санхүүгийн нөлөөний тооцооллыг тодруулна).

24. ТАЙЛАГНАЛЫН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Тэмдэглэл. (Тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцоолол зэргийг тодруулж бусад тайлбар, тэмдэглэл хийнэ).

³⁰ Тэргүүлэх удирдлагад ямар бүрэлдэхүүнийг хамруулснаа тодруулна. Тухайлбал, захирлуудын зөвлөл, удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт.

25. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨЛСӨН АЛБАН ТАТВАР, ТӨЛБӨР, ХУРААМЖ, НОГДОЛ АШИГ БОЛОН БУСАД ЗАРДЛЫН ТАЙЛАН

25.1 Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг болон бусад зардал

№	Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/
1	Албан татвар, төлбөр, хураамжийн дүн	
	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	
	Гаалийн албан татвар	
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	
	Онцгой албан татвар	
	Автобензин, дизелийн түлшний албан татвар	
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	
	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	
	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэл	
	Агаарын бохирдлын төлбөр	
	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж ³¹	
2	Бусад төлбөрийн дүн	
	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	
	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тухайн жилд гарын үсэг зурсны урамшуулал	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлсөн талбайн дэнчин	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлсөн захиргааны үйлчилгээний шимтгэл	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	
3	Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс, хураамжийн дүн	
	Гаалийн үйлчилгээний хураамж	
	Яам, төрийн захиргааны төв байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	
	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний үйлчилгээний хураамж	
4	Төрийн өмчид ногдох ногдол ашиг	
5	Засгийн газарт төлсөн төлбөрийн дүн	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	
	Үүнээс: эрхийн шимтгэл/рояльти	
6	Бусад	
	Торгууль	
7	Нийт дүн	

25.2 Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, бусад зардал

№	Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/
1	Албан татвар, төлбөр, хураамжийн дүн	
	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	
	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	
	Газрын төлбөр	
	Ус ашигласны төлбөр	
	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (түгээмэл тархацтай ашигт)	

³¹ “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль” – ийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгоход энэ хуулийн 10.6 – д заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана” гэж заасан.

	малтмалын)	
	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	
	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу орон нутгийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан төлбөр	
	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	
	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т зааснаас бусад	
2	Нутгийн захиргааны байгууллагад төлсөн хураамж, үйлчилгээний хөлс	
3	Бусад	
	Торгууль	
4	Нийт дүн	

25.3 Бусад зардал

№	Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/
1	Байгаль хамгаалах зардлын урьдчилгааны дүн	
	Байгаль хамгаалах зардлын 50% - г тусгай дансанд шилжүүлсэн дүн	
2	Бусад байгууллагад өгсөн хандив, дэмжлэгийн дүн³²	
	Бусад байгууллагад өгсөн мөнгөн хандив, дэмжлэг	
	Бусад байгууллагад өгсөн мөнгөн бус хандив, дэмжлэг	
3	Бусад зардлын дүн	

Бусад байгууллагад өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэгийг байгууллага тус бүрээр дэлгэрэнгүй харуулна.

³² “Төсвийн тухай” хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу үзүүлсэн мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэгийн дүн орно.

26. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЭДЭЭ

Аж ахуйн нэгжийн нэр:

Регистрийн дугаар:

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Тайланг хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт										Эцсийн үлдэгдэл
			Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр	Улсын төсвийн хөрөнгөөр	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Банкны зээл	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	Гадаадын зээл	Гадаадын буцалтгүй тусламж	Төсөл, хөтөлбөр, хандив	Бусад эх үүсвэр	Дүн	
1	Биет хөрөнгө:												
1.1	Газрын сайжруулалт												
1.2	Барилга, байгууламж												
1.2.1	Үүнээс: Орон сууцны барилга												
1.2.2	Авто зам												
1.3	М ашин тоног, төхөөрөмж												
1.4	Тээврийн хэрэгсэл												
1.5	Тавилга эд хогшил												
1.6	Компьютер, бусад хэрэгсэл												
1.7	Биологийн хөрөнгө												
1.8	Бусад биет хөрөнгө:												
1.9	Үүнээс: ХОЗҮХХ												
1.10	Биет хөрөнгийн дүн												
2	Биет бус хөрөнгө:												
2.1	Зохиогчийн эрх												
2.2	Компьютерийн программ хангамж												
2.2.1	Үүнээс: Программ хангамж												
2.2.2	Мэдээллийн сан												
2.3	Патент												
2.4	Барааны тэмдэг												
2.5	Тусгай зөвшөөрөл												
2.6	Газар эзэмших эрх												
2.7	Бусад биет бус хөрөнгө												
2.7.1	Үүнээс: Зураг төсвийн ажил, ТЭЗҮ боловсруулах, туршилт судалгаа												
2.8	Биет бус хөрөнгийн дүн												
3	Хайгуул үнэлгээний хөрөнгө												
3.1	Үүнээс: Биет хөрөнгө												
3.2	Биет бус хөрөнгө												
4	Нийт дүн												

ХОЗҮХХ – Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө